



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.24 № 3/367
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. M

Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2017\02\24\367.docx

070500



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахи хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын
газар

Засгийн газрын IY байр

Улаанбаатар-46 Бага тойруу 6

Web: www.mnao.gov.mn

Санхүүгийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663

И-мэйл: www.@audit.gov.mn

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

И-мэйл: www.@audit.gov.mn

Аудитор: Н.Нямдаваа
Утас: 260512

И-мэйл: www.audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:

“Бэст фортуна Аудит” ХХК

Утас: 324338

И-мэйл: fortune_audit@yahoo.com

Захирал: Ж.Оюунцэцэг

Утас: 89116465, 98056465

И-мэйл: Oyuntsetseg_cpa@yahoo.com

Аудитын багийн ахлагч:

Аудитор: Б.Нарангэрэл

Утас: 99839547

И-мэйл: bavaanarangerel@yahoo.com

АУДИТЫН ТАЙЛАН

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийгдсэн санхүүгийн
тайлан

Агуулга

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл	1
Байгууллагын хууль эрх зүйн орчин	1
Байгууллагын зорилго, үйл ажиллагаа	2
Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн	2
Материаллаг байдал	3
Дотоод хяналт	3
Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар	3
Шилэн дансны мэдээлэл	3
Олж тогтоосон гол эрсдлүүд	4
Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар	4
Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар	4-5
Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар	5
Анхаарал татахуйц бусад чухал асуудал	5
Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд	5
Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл	5
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	5
Дүгнэлт	6

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1, 18.5 дахь заалтуудыг үндэслэн Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Налайх Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн санхүүгийн тайланд “Бэст фортуна аудит” ХХК гэрээгээр аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хуулийн хүрээнд Аудитын Олон Улсын Стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө хөтөлбөрийн дагуу явуулав.

Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв /МСҮТ/-ийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилго байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Налайх дахь МСҮТөвийн 2016 оны завсрын аудитыг 2016 оны 09 дүгээр сарын 26-с 11 дүгээр сарын 14 хүртэл, жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитыг 2017 оны 01 дүгээр сарын 20-с 2017 оны 2 дугаар сарын 18-ны хооронд хийхээр төлөвлөн “Бэст фортуна Аудит” ХХК-ийн аудитын баг хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Налайх дахь МСҮТөв нь 2016 оны санхүүгийн тайланг 2017 оны 1 дүгээр сарын 20-нд “Бэст фортуна Аудит” ХХК-нд ирүүлсэн байна.

“Бэст фортуна Аудит” ХХК нь аудитыг 2017 оны 1 дүгээр сарын 21-нээс 2 дугаар сарын 13-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 2 дугаар сарын 15-нд Налайх дахь МСҮТөвийн удирдлагад танилцуулна.

2. Байгууллагын хууль эрх зүйн орчин:

Налайх дахь МСҮТөвийн удирдлага нь Монгол Улсын Төсвийн тухай хууль, Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль, Төрийн болон орон нутгийн

өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлангийн хугацаанд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан журам зааварт өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа Налайх дахь МСҮТөв нь геологи, уул уурхай, эрчим хүч, барилгын чиглэлээр мэргэжилтэй ажилтан бэлтгэдэг, 1954 онд байгуулагдсан, улсын ууган сургуулиудын нэг.

Эрхэм зорилго нь:

Уул уурхай, эрчим хүч, геологийн салбарын эрэлтэд нийцүүлэн мэргэжлийн сургалтаар тэргүүлэгч байж, олон улсын түвшинд зөвшөөрөгдөх чадвар бүхий мэргэжилтэй ажилтан бэлтгэх

Зорилтууд:

Чадамжид суурилсан сургалтын тогтолцоонд бүрэн шилжих

Нийгмийн түншлэлийн хүрээг өргөтгөн, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцсэн элсэлт, төгсөлтийн бодлогыг хэрэгжүүлэх

Сургалтын орчин, тоног төхөөрөмж, хэрэглэгдэхүүнийг шинэчлэхэд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчидтай хамтын ажиллагаагаа улам өргөжүүлэх

Хүний нөөцийн цөмийг бүрдүүлж, хөгжлийг хангаж, соёл, үнэт зүйлсийг эрхэмлэн дэлгэрүүлэх

Тус сургууль нь сургалтын алба, нийгмийн түншлэл олон нийттэй харилцах алба, санхүү-аж ахуйн алба гэсэн 3 албанд нийт 90 гаруй багш, ажилтантай, мэргэжлийн боловсрол олгох 2.5, мэргэжил олгох /насанд хүрэгчдийн болон захиалгат/ 1 жилийн сургалтаар мэргэжилтэй ажилчин бэлтгэдэг.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5-д “агентлагийн дарга тус агентлагийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн захирал Төсвийн захирагчийн үүрэг гүйцэтгэж байна. Налайх дахь МСҮТөвийн 2016 оны төсвийг Налайх дүүргийн төрийн сангаас олгож байна. Төсвийн захирагчтай шууд холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг ажилдаа мөрдлөг болгон ажиллаж байна.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, сорилууд түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашигласан болно.

Аудитаар Налайх дахь МСҮТөвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн шууд захирагчийн бэлтгэсэн санхүүгийн тайлан нь

материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжуулав. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, материаллаг дүнтэй зарим гүйлгээнүүдийг түүвэрчилсэн байдлаар аудитын 13 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Хөдөлмөр нийгэм хамгаалалын яамнаас батлагдсан нэгдсэн загварыг үндэслэн өөрийн онцлогт тохируулан боловсруулж, МСҮТөвийн захирлын 2015 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/139 дугаар тушаалаар батлан мөрдөн ажиллаж байна.

Налайх дахь МСҮТөвийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах, программд нэвтрэх зэрэг аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэсэн болно. /ТАБ-СТА-В-2/

Санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, боловсруулах үйл ажиллагааг "Acolous" санхүүгийн программыг ашиглан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг бэлтгэн гаргасан байна.

5. Материаллаг байдал

Төлөвлөлтийн шатанд материаллаг байдлыг тооцохдоо 2016 оны 2 дугаар улирлын батлагдсан төсвийн зардлаар суурь үзүүлэлт болгон сонгож 1.0 хувиар буюу 9,256.7 мянган төгрөгөөр тооцсон ба гүйцэтгэлийн шатанд 2016 оны нийт зардлын гүйцэтгэлийг суурь болгон сонгож 1.0 хувиар тооцон 17,174.9 мянган төгрөгөөр тогтоов.

6. Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Налайх дахь МСҮТөвийн дотоод хяналтын эрсдлийн 2 эрсдэл үр нөлөөтэй, 22 эрсдэл үр нөлөөгүй гэж тооцсон. /ТАБ-СТА-А-4-өөс үзнэ үү/

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар

2016 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу Налайх дүүргийн төрийн сан тус байгууллагын банкин дахь харилцах дансаар олгож, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн санхүүжилтийн гүйцэтгэл, төсвийн зардлын төрөл зүйлээр хуваарилан зарцуулалтанд хяналт тавьж ажилласан байна.

Налайх дахь МСҮТөвийн үйл ажиллагааны төсөв 2016 онд 1,395,671.2 мянган төгрөгөөр батлагдснаас 1,385,643.8 мянган төгрөгийн санхүүжилт авч төсвийг хэтрүүлээгүй байна.

Бусад авлага 7,236.9 мянган төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь НДШ-д 4,799.8 мянган төгрөг, ХХОАТ-т 2,437.2 мянган төгрөг тус тус илүү төлсөнтэй холбоотой байна.

Тайланд тусгасан бараа материал, үндсэн хөрөнгө нь бодитойгоор оршин байгаа ба байгууллагын өмчлөлд байгаа бүхий л өмч хөрөнгийг бүрэн хамруулж, орлого, зарлага болон шилжилт хөдөлгөөн, бусад зарлагын гүйлгээнүүд нь данс, дүн, хугацаа, ангиллын хувьд үнэн зөв бүртгэгдсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны цахим хуудас болох www.shilendans.gov.mn хуудсанд 2016 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл оруулсан байна.

Байгууллагын цахим хуудсанд байгууллагын мэдээлэлүүд, 2016 оны төсвийн гүйцэтгэлийг оруулсан байна. Байгууллагын самбараар дамжуулан төсөв, төсвийн гүйцэтгэлийн мэдээллийг суралцагсад болон иргэдэд нээлттэй хүргэж байна.

9. Олж тогтоосон гол эрсдлүүд

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 24 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 13 горим, сорил гүйцэтгэж доорхи эрсдлүүдийг олж тогтоов. /ТАБ-СТА-В-3-аас үзнэ үү/ Үүнд:

Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналт сул байх

Материал буруу ангилагдан бүртгэгдсэн байх

Хөрөнгө, зардал буруу ангилагдан бүртгэгдсэн байх

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар

МСҮТөвийн Мастерын газрын дээврийн засварын ажлыг 74,900.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн хөрөнгөөр гүйцэтгэж, барилгын өртгийг капиталжуулсан

Хөдөлмөрийн яамны хөрөнгө оруулалтаар 55,269.5 мянган төгрөгийн тоног төхөөрөмж худалдан авсан.

Сангийн яамны 2016 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 3101 дугаар албан бичгээр Дархан-Уул аймаг дахь Уул уурхай, эрчим хүчний политехникийн коллежоос балансаас балансад 2,020.9 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,486.0 мянган төгрөгийн бараа материал бүгд 3,506.9 мянган төгрөгийн хөрөнгө шилжүүлэн авсан

Төрийн өмчийн хорооны 2015 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 784 дүгээр тогтоолоор 3,789.1 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, 1,047.3 мянган төгрөгийн номын фонд нийт 4,836.4 мянган төгрөгийн хөрөнгө акталж данснаас хассан

Налайх дүүргийн Татварын хэлтсийн татварын улсын байцаагчийн 2016 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 290005997 дугаар актаар 3,023.6 мянган төгрөгийн нөхөн татвар, торгууль төлсөн

11. Аудитаар илэрсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтуудад хураангуйлан тэмдэглэв.

Аудитын явцад материаллаг хэмжээтэй алдаа зөрчлүүд нь санхүүгийн тайлангийн эрх үүрэг, тохиолдсон байх, үнэлгээ, хэмжилт гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байсан ба холбогдох хуулийн заалтуудыг зөрчсөн байна. Үүнд:

1. Тухайн сарын дулаан, цахилгаан, ус ашиглалтын болон холбоо, интернэтийн үйлчилгээний зардлуудыг төлөхдөө нийлүүлэгчийн нэхэмжлэлээс зөрүүтэй дүнгээр төлсөн нь Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь хэсэгт заасан **“Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”** гэсэн заалтыг биелүүлээгүй

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** 2016 оны цахилгаан, дулаан, ус ашиглалтын болон холбоо, интернэтийн үйлчилгээний нэхэмжлэл, төлсөн дүнгүүдийг тулган шалгахад материаллаг хэмжээний зөрүү гараагүй тул төлбөрийг нэхэмжлэлийн дагуу төлж байх зөвлөмж өгөв

2. 00001190 кодтой номын үлдэгдэл /номнууд/ 0.69, 00002143 кодтой Цахим номнууд 1 ширхэг 4,400.0 мянган төгрөг гэх мэтээр номнуудыг багцалж үнэлсэнээс багцад байх тоо, номын нэр, төрөл тодорхой бус байгаа нь нягтлан бодогч **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь хэсэгт заасан “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар ... –ыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”** гэсэн үүргээ бүрэн биелүүлээгүй

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Багцад байх номын тоо, нэр төрөл тодорхой бус байгаагаас хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сулрах, өмч хөрөнгө үрэгдэх эрсдэлтэй тул хөрөнгүүдийн нэр төрөл, тоо ширхэгийг тодорхой болгон бүртгэлд өөрчлөлт оруулах зөвлөмж өгөв.

3. 10,904,9 мянган төгрөгийн үнэ бүхий 11 нэрийн /хаалга, гагнуурын аппарат, майхан, ногоо хэрчигч, төмөр шат, цаг бүртгэлийн систем, гар багаж дорцов, гар багаж, түлхүүр, эмнэлгийн анхны тусламж, өдөр шөнийн камер, бичлэг хийгч/ үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг эргэлтийн хөрөнгө /Аж ахуйн материалын данс/-д бүртгэсэн нь нягтлан бодогч **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь хэсэгт заасан “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох**

бүртгэлийн стандарт, журам, заавар ... –ыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэн үүргээ бүрэн биелүүлээгүй

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Хөрөнгийг буруу ангилан бүртгэснээс санхүүгийн тайлангийн үзүүлэлт алдаатай илэрхийлэгдэх эрсдэлтэй тул хөрөнгийн чанар байдлыг дахин үнэлж, хөрөнгийн ангиллыг зөв хийн бүртгэлд тусгах зөвлөмж өгөв.

4. 2016 онд ХХОАТ-т 2,437.2 мянган төгрөг, НДШ-д 4,799.7 мянган төгрөг, нийт 7,236.9 мянган төгрөг илүү төлсөнөөс авлага үүссэн нь нягтлан бодогч **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь хэсэгт заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”** гэсэн үүргээ бүрэн биелүүлээгүй

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Татвар, нийгмийн даатгалын байгууллагатай хийх тооцоог улирал бүр нийлж, үлдэгдлийг баталгаажуулж байх. Шинээр өр, авлага үүсгэхгүй байх

5. 2016 оны батлагдсан төсөв дүнгээрээ хэтрээгүй боловч хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал 333.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 2,625.0 мянган төгрөгөөр хэтэрсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т заасан **“Бүх шатны төсвийн захирагч нар батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”** гэсэн үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

- ✓ **Шийдвэрлэсэн нь:** Зардлын бүлэг доторх зарим зардал хэмнэсэн, хэтэрсэн өөрчлөлттэй байгаа нь “Төсвийн санхүүжилтийн эрх болон зарцуулалтын эрхийн тухай” Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалаар баталсан журмыг үндэслэн бүлэг доторх зардлыг гүйлгэн зарцуулсан байна. 2017 онд батлагдсан төсвийн хуваарийг баримтлан ажиллахыг зөвлөв.

12. Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар

Залруулагдаагүй алдаа байхгүй.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц бусад асуудал байгаагүй болно.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад үзэж амжаагүй асуудал байхгүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитаар байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 10,904.9 мянган

төгрөгийн зөрчил илэрсэн ба дээрх зөрчил нь Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагаанаас үл хамаарсан болно.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх аудитыг хийсэн “Нийслэл аудит” ХХК-аас өгөгдсөн 4 зөвлөмж хэрэгжсэн байна

17. Зөрчилгүй санал дүгнэлт

Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүнгийн тайлан, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон илчлэл тодруулгуудад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.



НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараахи хаягаар харилцана уу:

Монгол Улсын Үндэсний Аудитын газар
Засгийн газрын IY байр
Улаанбаатар-46 Бага тойруу 6

Web: www.mnao.gov.mn

Санхүүгийн аудитын газрын дарга
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663

И-мэйл: www.audit.gov.mn

Аудитын менежер Я.Самбууням
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитор Н.Нямдаваа
Утас: 260512
И-мэйл: www.audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
“Бэст фортуна Аудит” ХХК
Утас: 324338
И-мэйл: fortune_audit@yahoo.com

Захирал: Ж.Оюунцэцэг
Утас: 89116465, 98056465
И-мэйл: Oyuntsetseg_cpa@yahoo.com

Аудитын багийн ахлагч:
Аудитор: Б.Нарангэрэл
Утас: 99839547
И-мэйл: bavaanarangerel@yahoo.com

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Тэргүүлэх ач холбогдол №2

**Асуудал 1: Төсвийн хөрөнгийн
зарцуулалт**

Асуудал 2: Хөрөнгийн бүртгэл

Асуудал 3: Авлага өглөг

Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Налайх дахь Мэргэжлийн сургалт үйлдвэлзэлийн төвийн удирдлагад зориулан бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгасан болно.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг танай байгууллагын бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад хамтран ажилласан МСҮТөвийн удирдлага болон бусад ажилтануудад талархал илэрхийлье.

Асуудал 1: Төсвийн хөрөнгийн зарцуулалт

Аудитын ажиглалт

1. Тухайн сарын дулаан, цахилгаан, ус ашиглалтын болон холбоо, интернэтийн үйлчилгээний зардлуудыг төлөхдөө нийлүүлэгчийн нэхэмжлэлээс зөрүүтэй дүнгээр төлсөн нь Монгол Улсын **Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 дахь хэсэгт заасан “Санхүүгийн аливаа үйл ажиллагааг нягтлан бодох бүртгэлийн олон улсын болон үндэсний стандартын дагуу, цаг хугацаанд нь, үнэн зөв, үндэсний мөнгөн тэмдэгтээр илэрхийлэн бүртгэж, тайлагнах”** гэсэн заалтыг биелүүлээгүй
2. 2016 оны батлагдсан төсөв дүнгээрээ хэтрээгүй боловч хөдөлмөр хамгааллын хэрэгслийн зардал 333.9 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардал 2,625.0 мянган төгрөгөөр хэтэрсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2-т заасан **“Бүх шатны төсвийн захирагч нар батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”** гэсэн үүргээ бүрэн биелүүлээгүй байна.

Эрсдэл

Төсвийн хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр тавих хяналт сулрах, төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах

(Оршин байх, тохиолдсон байх)

Тэргүүлэх ач холбогдол № 2

Аудитын зөвлөмж

1. 2016 оны цахилгаан, дулаан, ус ашиглалтын болон холбоо, интернэтийн үйлчилгээний нэхэмжлэл, төлсөн дүнгүүдийг тулган шалгахад материаллаг хэмжээний зөрүү гараагүй тул төлбөрийг нэхэмжлэлийн дагуу төлж байх
2. Төсвийн тухай хуулийг биелүүлж, батлагдсан төсвийн хуваарийг баримталж ажиллах

Үйлчлүүлэгчийн хариу

1. Ашиглалтын болон үйлчилгээний зардлуудыг нийлүүлэгчийн нэхэмжлэлийн дагуу төлж байна.
2. Зардлын бүлэг доторх зарим зардал хэмнэсэн, хэтэрсэн өөрчлөлттэй байгаа нь “Төсвийн санхүүжилтийн эрх болон зарцуулалтын эрхийн тухай” Сангийн сайдын 2013 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн 73 дугаар тушаалаар баталсан журмыг үндэслэн бүлэг доторх зардлыг гүйлгэн зарцуулсан. Мөн 2016 онд өөрийн орлогын төлөвлөгөө 5,300.0 мянган төгрөгөөр давсан орлогоос 2,600.0 мянган төгрөгийг сурагчдын гарын авлага, сурах эрхийн бичгийн эрхийн үнэд зарцуулан “Бараа үйлчилгээний бусад зардал”-д тайлагнасан нь төсөвлөгдөөгүй зардал гарсан харагдаж байна. 2017 онд батлагдсан төсвийн хуваарийг баримтлан зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана.

Аудитын ажиглалт

1. 00001190 кодтой номын үлдэгдэл /номнууд/ 0.69, 00002143 кодтой Цахим номнууд 1 ширхэг 4,400.0 мянган төгрөг гэх мэтээр номнуудыг багцалж үнэлсэнээс багцад байх тоо, номын нэр, төрөл тодорхой бус;

3. 580.0 мянган төгрөгний хаалга, 250.0 мянган төгрөгний гагнуурын аппарат, 500.0 мянган төгрөгний майхан, 350.0 мянган төгрөгний ногоо хэрчигч, 400.0 мянган төгрөгний төмөр шат, 830.0 мянган төгрөгний цаг бүртгэлийн систем, 1,470.8 мянган төгрөгний гар багаж дорцов, 500.0 мянган төгрөгний гар багаж, түлхүүр, 4,474.1 мянган төгрөгний эмнэлгийн анхны тусламж, 1,100.0 мянган төгрөгний өдөр шөнийн камер, 450.0 мянган төгрөгний бичлэг хийгч зэрэг үндсэн хөрөнгийн шинжтэй хөрөнгүүдийг эргэлтийн хөрөнгө /Аж ахуйн материалын данс/-д бүртгэсэн нь 00001190 кодтой номын үлдэгдэл /номнууд/ 0.69, 00002143 кодтой Цахим номнууд 1 ширхэг 4,400.0 мянган төгрөг гэх мэтээр номнуудыг багцалж үнэлсэнээс багцад байх тоо, номын нэр, төрөл тодорхой бус байгаа нь нягтлан бодогч **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь хэсэгт заасан “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар ... –ыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах”** гэсэн үүргээ бүрэн биелүүлээгүй

Эрсдэл

Хөрөнгийн нэр төрөл, тоо хэмжээ тодорхой бусаас өмч хөрөнгө үрэгдэх, хөрөнгийг буруу ангилан бүртгэснээс санхүүгийн тайлангийн үзүүлэлт алдаатай илэрхийлэгдэх эрсдэлтэй

(Оршин байх, тохиолдсон байх)

Аудитын зөвлөмж

1. Багцад байх номын тоо, нэр төрөл тодорхой бус байгаагаас хөрөнгөнд бүртгэлээр тавих хяналт сулрах, өмч хөрөнгө үрэгдэх эрсдэлтэй тул хөрөнгүүдийн нэр төрөл, тоо ширхэгийг тодорхой болгон бүртгэлд өөрчлөлт оруулах.
2. Хөрөнгийг буруу ангилан бүртгэснээс санхүүгийн тайлангийн үзүүлэлт алдаатай илэрхийлэгдэх эрсдэлтэй тул хөрөнгийн чанар байдлыг дахин үнэлж, хөрөнгийн ангиллыг зөв хийн бүртгэлд тусгах

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

Асуудал 3: Авлага, өглөг

Аудитын ажиглалт

2016 онд ХХОАТ-т 2,437.2 мянган төгрөг, НДШ-д 4,799.7 мянган төгрөг, нийт 7,236.9 мянган төгрөг илүү төлсөнөөс авлага үүссэн нь нягтлан бодогч **Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь хэсэгт заасан “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”** гэсэн үүргээ бүрэн биелүүлээгүй

Эрсдэл

Төсвийн хөрөнгө үр ашиггүй зарцуулагдах, найдваргүй өр, авлага үүсэх

(Оршин байх, тохиолдсон байх)

Тэргүүлэх ач холбогдол № 2

Аудитын зөвлөмж

2017 онд өглөг, авлагыг барагдуулах, цаашид өр авлага үүсгэхгүй байх зөвлөмж өгөв.

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийг хэрэгжүүлнэ.

НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

12/31/2016

ҮЗҮҮЛЭЛТ	2015-12-31	2016-12-31
МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ	-	404.00
Кассад байгаа бэлэн мөнгө		404.00
Банкинд байгаа бэлэн мөнгө/төгрөгөөр/		-
АВЛАГА	-	7,236,947.78
Бусад авлага	-	7,236,947.78
БАРАА МАТЕРИАЛ	191,588,471.73	217,847,417.37
Хангамжийн материал	185,927,812.73	204,968,247.37
Мал амьтад		-
Бусад	5,660,659.00	12,879,170.00
Нөөцийн бараа		-
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		-
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,665,947,040.39	2,414,276,971.12
Биет хөрөнгө	2,662,380,438.25	2,414,276,971.12
Барилга, байгууламж	5,198,036,887.00	5,277,426,407.00
Хуримтлагдсан элэгдэл	(3,429,367,469.24)	(3,496,554,265.28)
Авто-тээврийн хэрэгсэл	106,883,800.00	106,883,800.00
Хуримтлагдсан элэгдэл	(46,842,133.21)	(63,075,466.45)
Машин, тоног төхөөрөмж	1,391,231,507.50	1,450,502,789.56
Хуримтлагдсан элэгдэл	(840,066,099.27)	(1,105,411,361.38)
Тавилга, аж ахуйн эд хогшил	379,230,553.86	379,230,553.86
Хуримтлагдсан элэгдэл	(125,791,303.55)	(164,368,905.35)
Номын фонд	29,064,695.16	29,643,419.16
Биет бус хөрөнгө	3,566,602.14	0
Програм хангамж	-	-
Хуримтлагдсан элэгдэл	-	-
Бусад	19,390,558.00	19,390,558.00
Хасагдуулга	(15,823,955.86)	(19,390,558.00)
БУСАД ХӨРӨНГӨ		-
Урт хугацаат хөрөнгө оруулалт		-
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,414,276,971.12
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	-	2,414,276,971.12
Богино хугацаат өр төлбөр	122,641,929.00	
Өглөг	122,641,929.00	-
Бараа үйлчилгээний зардлын өглөг	2,375,169.00	-
Бусад өглөг	120,266,760.00	-
БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	122,641,929.00	-
НИЙТӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	122,641,929.00	-
Засгийн газрын оруулсан капитал	1,693,760,852.09	1,693,760,852.09
Хуримтлагдсан үр дүн		-
Өмнөх үеийн үр дүн	(860,678,029.41)	(759,813,489.41)
Тайлант үеийн үр дүн		(196,396,382.05)
Дахин үнэлгээний зөрүү	1,901,810,760.44	1,901,810,760.44
ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	2,734,893,583.12	2,639,361,741.07
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ / ӨМЧИЙН ДҮН	2,857,535,512.12	2,639,361,741.07

НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2015-12-31	2016-12-31
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО	-	-
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	-
Улсын төсвөөс	1,598,676,123.08	1,385,643,800.00
Урсгал	1,356,076,780.00	1,465,043,800.00
Нэмэлт санхүүжилтийн орлогоос	242,599,343.08	79,400,000.00
Төсвийн урамшуулал	14,021,476.08	
Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс		
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	228,577,867.00	79,400,000.00
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	28,359,500.00	169,305,394.00
Төсөвт байгууллагын ажил, үйлчилгээний орлого	28,359,500.00	169,305,394.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	725,000.00	13,329,014.00
Үнэ төлбөргүй орлого	27,634,500.00	155,976,380.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,627,035,623.08	1,634,349,194.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	1,792,736,090.13	1,717,493,753.05
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	884,346,702.00	835,400,755.22
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	796,436,428.00	751,896,055.22
Цалин	796,436,428.00	751,896,055.22
Нийгмийн хамгааллын шимтгэл	87,910,274.00	83,504,700.00
Тэтгэвэр болон тэтгэмжийн шимтгэл	72,427,334.00	68,322,000.00
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	56,083,000.00	53,139,300.00
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	3,871,740.00	6,073,100.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,552,660.00	7,591,300.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	3,919,934.00	1,518,300.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	15,482,940.00	15,182,700.00
Хангамж, бараа материалын зардал	23,197,485.00	35,906,159.00
Бичиг хэргийн материал	18,656,785.00	24,110,537.00
Тээвэр, шатахууны зардал	1,988,400.00	4,071,800.00
Шуудан холбооны зардал	2,193,800.00	7,576,512.00
Ном, хэвлэлийн зардал	358,500.00	-
Бага үнэтэй, түргэн элэгдэх зүйлс	-	147,310.00
Тогтмол зардал	197,985,900.00	200,272,009.00
Гэрэл цахилгаан зардал	17,968,265.00	19,155,777.00
Түлш, халаалтын зардал	162,409,939.00	164,114,850.00
Цэвэр, бохир усны зардал	17,607,696.00	17,001,382.00
Томилолт, зочны зардал	2,601,360.00	1,852,968.00
Дотоод томилолтын зардал	2,601,360.00	1,852,968.00
Нормативт зардал	39,312,427.52	37,316,117.64
Эм	174,000.00	275,000.00
Хоол	38,910,427.52	36,421,217.64
Нормын хувцас зөөлөн эдлэл	228,000.00	619,900.00
Эд хогшил, урсгал засварын зардал	38,265,862.00	108,775,904.40
Хөдөлмөр хамгааллын зардал	281,600.00	415,000.00
Урсгал засвар	37,984,262.00	108,360,904.40
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төрөл	15,828,070.00	33,575,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	14,500,000.00	29,992,500.00
Аудит баталгаажуулалтын зардал		3,467,500.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	330,000.00	625,182.00
Тээврийн хэрэгсэлийн оношилгоо	10,000.00	300,000.00
Тээврийн хэрэгсэлийн татвар	346,590.00	158,400.00
Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	626,680.00	

Улсын мэдээллийн маягтын зардал	14,800.00	115,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал	591,198,283.61	463,581,257.79
Бусад зардал		1,486,300.00
Хичээл сургалт үйлдвэрлэлийн зардал	63,920,322.00	67,396,284.52
Элэгдлийн зардал	527,277,961.61	394,698,673.27
Төвлөрүүлэн шилжүүлэг	-	
Урсгал шилжүүлэг	481,719,131.08	112,204,547.00
Төвлөрүүлэн шилжүүлэг		
Засгийн газрын урсгал шилжүүлэг	48,380,308.08	26,287,859.00
Засгийн газрын дотоод шилжүүлэг	48,380,308.08	26,287,859.00
Бусад урсгал шилжүүлэг	433,338,823.00	85,916,688.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	329,442,407.00	
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан	75,179,896.00	71,080,408.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	28,716,520.00	14,836,280.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	2,274,455,221.21	1,829,698,300.05
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(647,419,598.13)	(195,349,106.05)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн олз (бодит)	-	-
Үндсэн хөрөнгө худалдсаны олз	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	-	-
Гадаад валютын ханшийн зөрүүгийн гарз (бодит)	-	-
Хөрөнгө худалдсаны гарз	-	1,047,276.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	-	1,047,276.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	(647,419,598.13)	(196,396,382.05)

НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

АУДИТЛАГДСАН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	2015-12-31	2016-12-31
БАРАА ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ОРЛОГО	725,000.00	13,329,014.00
Төсөвт байгууллагын өөрийн орлого	725,000.00	13,329,014.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	725,000.00	13,329,014.00
ТАТААС, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,598,676,123.08	1,465,043,800.00
Улсын төсвөөс	1,356,076,780.00	1,385,643,800.00
Урсгал	1,356,076,780.00	1,385,643,800.00
Нийгмийн даатгалын сангаас		
Нэмэлт санхүүжилтийн орлого	242,599,343.08	79,400,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан	228,577,867.00	79,400,000.00
Төсвийн урамшуулал	14,021,476.08	
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,599,401,123.08	1,478,372,814.00
АЖИЛЛАГЧИДТАЙ ХОЛБОГДСОН ЗАРДАЛ	867,239,872.00	842,637,703.00
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	779,329,598.00	759,133,003.00
Цалин	779,329,598.00	759,133,003.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	87,910,274.00	83,504,700.00
Тэтгэврийн даатгалийн шимтгэл	56,083,000.00	53,139,300.00
Тэтгэмжийн даатгалийн шимтгэл	6,189,374.00	6,073,100.00
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	8,011,800.00	7,591,300.00
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,602,300.00	1,518,300.00
Эрүүл мэндийн даатгалын хураамж	16,023,800.00	15,182,700.00
Бараа ажил үйлчилгээний урсгал зардал	195,438,881.00	206,885,128.00
Гэрэл цахилгааны зардал	17,968,265.00	20,347,327.00
Түлш, халаалтын зардал	160,034,770.00	167,975,419.00
Цэвэр, бохир усны зардал	17,435,846.00	18,562,382.00
Хангамж, бараа материалын зардал	11,076,537.00	22,607,852.00
Бичиг хэргийн материал	6,323,687.00	7,921,800.00
Тээвэр, шатахууны зардал	2,172,850.00	4,071,800.00
Шуудан холбооны зардал	2,193,800.00	8,898,652.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,715,600.00
Ном, хэвлэлийн зардал	386,200.00	
Нормативт зардал	40,238,563.00	56,407,936.00
Эм бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	164,563.00	417,940.00
Хоол хүнс	39,358,000.00	44,974,836.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	716,000.00	11,015,160.00
Эд хогшил, урсгал засварын зардал	12,394,900.00	92,171,748.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	1,999,400.00	2,224,800.00
Урсгал засвар	10,395,500.00	89,946,948.00
Томилолт, зочны зардал	2,726,960.00	2,154,001.00
Дотоод албан томилолт	2,726,960.00	2,154,001.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	4,538,980.00	38,846,170.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээ		31,860,000.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		3,489,768.00
Тээврийн хэрэгслийн татвар	1,170,000.00	1,653,800.00
Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,000,000.00	30,000.00
Мэдээллийн технологийн үйлчилгээ	1,402,680.00	
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлдэх	466,300.00	829,720.00
Даатгалын үйлчилгээ	500,000.00	982,882.00
Бараа үйлчилгээний бусад зардал	75,728,342.00	80,012,609.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	75,366,616.00	77,387,609.00

Бусад	361,726.00	2,625,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	379,485,438.08	130,829,667.00
Засгийн газрын дотоод шилжүүлэг	48,380,308.08	26,287,859.00
Бусад урсгал шилжүүлэг	331,105,130.00	104,541,808.00
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	228,577,867.00	
Тэтгэвэрт гарахад олгон нэг удаагийн мөнгөн тэтгэмж	10,091,400.00	33,461,400.00
Хөдөө тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс	92,435,863.00	71,080,408.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (II)	1,588,868,473.08	1,472,552,814.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(III)=(I)-(II)	10,532,650.00	5,820,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		-
Гарсан зардлаа дансны нэгдсэн жагсаалтаас авах		-
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРЛАГЫН ДҮН (V)	10,532,650.00	5,820,000.00
Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	10,532,650.00	5,820,000.00
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ(4)=(4)-(V)	(10,532,650.00)	(5,820,000.00)
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
САНХҮҮГИЙН АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ ДҮН(8)		-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (IX)=(VII)+(VIII)	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үдэгдэл		-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		-

НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

АУДИТЛАГДСАН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2016 он 12 сар 31 өдөр

Д/Д	ҮЗҮҮЛЭЛТ	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2015 оны 01-р сарын 01-ээр үлдэгдэл	1,693,760,852.09	1,902,636,815.04	(319,407,586.14)	-	3,276,990,080.99
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын еерчлелт	-		826,054.60	-	826,054.60
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,693,760,852.09	1,902,636,815.04	(318,581,531.54)	-	3,277,816,135.59
4	Үндсэн херенгийн дахин үнэлгээний есөлт	-		-	-	-
5	Үндсэн херенгийн дахин үнэлгээний бууралт	-		-	-	-
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-	-
7	Тайлант үеийн үр дүн	-		(647,419,598.13)	-	(647,419,598.13)
8	2015 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,693,760,852.09	1,902,636,815.04	(860,678,029.41)	-	2,735,719,637.72
9	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын еерчлелт			100,864,540.00	-	100,864,540.00
10	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,693,760,852.09	1,902,636,815.04	(759,813,489.41)	-	2,836,584,177.72
11	Үндсэн херенгийн дахин үнэлгээний есөлт	-		-	-	-
12	Үндсэн херенгийн дахин үнэлгээний бууралт	-		-	-	-
13	Орлогын тайланд хилээн зөвшөөрөөгүй олз, гарз	-		-	-	-
14	Тайлант үеийн үр дүн	-		(196,396,382.05)	-	(196,396,382.05)
15	2016 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл	1,693,760,852.09	1,902,636,815.04	(956,209,871.46)	-	2,539,323,255.67

НАЛАЙХ ДАХЬ МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВ

АУДИТЛАГДСАН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Сарын гүйцэтгэл	Хувь
Мөнгөн хөрөнгийн оны эхнийн үлдэгдэл			-	
I.НИИТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II+V)	1,395,671,000.00	1,372,684,551.00	22,986,449.00	98.4
II.НИИТ ЗАРЛАГЫН ДҮН (III+IV)	1,395,671,000.00	1,372,684,551.00	22,986,449.00	98.4
III.УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	1,395,671,000.00	1,372,684,551.00	22,986,449.00	98.4
Бараа ажил үйлчилгээний зардал	1,280,985,600.00	1,268,142,743.00	12,842,857.00	99.0
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	759,133,000.00	759,133,033.00	(33.00)	100.0
Үндсэн цалин	759,133,000.00	759,133,033.00	(33.00)	100.0
Нийгмийн хамгааллын шимтгэл	83,504,400.00	83,504,400.00	-	100.0
Тэтгэврийн даатгал	53,139,000.00	53,139,000.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	6,073,100.00	6,073,100.00	-	100.0
ҮОМШ өвчний даатгал	7,591,300.00	7,591,300.00	-	100.0
Ажилгүйдлын даатгал	1,518,300.00	1,518,300.00	-	100.0
Байнууллага төлөх ЭМД-н хураамж	15,182,700.00	15,182,700.00	-	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	212,908,700.00	206,885,128.00	6,023,572.00	97.2
Гэрэл цахилгааны зардал	24,226,200.00	20,347,327.00	3,878,873.00	84.0
Түлш, халаалтын зардал	167,562,500.00	167,975,419.00	(412,919.00)	100.2
Цэвэр, бохир усны зардал	21,120,000.00	18,562,382.00	2,557,618.00	87.9
Хангамж, бараа материалын зардал	24,814,500.00	24,551,388.00	263,112.00	98.9
Бичиг хэргийн материал	8,226,200.00	7,971,396.00	254,804.00	96.9
Тээвэр, шатахууны зардал	4,072,900.00	4,071,800.00	1,100.00	100.0
Шуудан холбооны зардал	8,908,200.00	8,898,652.00	9,548.00	99.9
Бага үнтэй түргэн борлогдох аж ахуйн эд зүйлс	3,607,200.00	3,609,540.00	(2,340.00)	100.1
Норматив зардал	68,756,000.00	59,632,936.00	9,123,064.00	86.7
Эм бэлдмэл, эмнэлэгийн хэрэгсэл	500,000.00	417,940.00	82,060.00	83.6
Хоол хүнс	54,022,000.00	44,974,836.00	9,047,164.00	83.3
Нормын зөөлөн эдлэл	14,234,000.00	14,240,160.00	(6,160.00)	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	12,436,800.00	12,771,748.00	(334,948.00)	102.7
Хөдөлмөр хамгаалалын хэрэгсэл	1,890,900.00	2,224,800.00	(333,900.00)	117.7
Урсгал засварын зардал	10,545,900.00	10,546,948.00	(1,048.00)	100.0
Томилолт, зочны зардал	2,132,700.00	2,154,001.00	(21,301.00)	101.0
Дотоод томилолтын зардал	2,132,700.00	2,154,001.00	(21,301.00)	101.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	39,030,000.00	38,846,170.00	183,830.00	99.5
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	31,860,000.00	31,860,000.00	-	100.0
Аудитаар баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	3,500,000.00	3,489,768.00	10,232.00	99.7
Даатгалын үйлчилгээ	1,000,000.00	982,882.00	17,118.00	98.3
Тээврийн хэрэгсэлийн татвар	1,640,000.00	1,653,800.00	(13,800.00)	100.8
Тээврийн хэрэгсэлийн оншилгоо	30,000.00	30,000.00	-	100.0
Улсын мэдээллийн маягт хэвлэх бэлтгэх	1,000,000.00	829,720.00	170,280.00	83.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ	78,269,200.00	80,663,669.00	(2,394,469.00)	103.1
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил	78,269,200.00	2,625,000.00	75,644,200.00	3.4

Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	78,269,200.00	78,038,669.00	230,531.00	99.7
Урсгал засварын зардал	114,685,600.00	104,541,808.00	10,143,792.00	91.2
Бусад урсгал шилжүүлэг	114,685,600.00	104,541,808.00	10,143,792.00	91.2
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,461,300.00	33,461,400.00	(100.00)	100.0
Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласаны тэтгэмж	81,224,300.00	71,080,408.00	10,143,892.00	87.5
Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр	1,395,671,200.00	1,398,972,814.00	(3,301,614.00)	100.2
Үндсэн үйл ажиллагааны орлогоос шилжүүлэх	10,000,000.00	13,329,014.00	(3,329,014.00)	133.3
Төсвөөс шилжүүлэх	1,385,671,200.00	1,385,643,800.00	27,400.00	100.0
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		-	-	
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		404.00	(404.00)	
БАЙГУУЛЛАГЫН ТОО			-	
Ажиллагсад бīгд	89.00	90.00	(1.00)	101.1
Удирдах ажилтан	3.00	3.00	-	100.0
Гүйцэтгэх ажилтан	50.00	54.00	(4.00)	108.0
Үйлчилэх ажилтан	36.00	33.00	3.00	91.7
Ерөнхий боловсролын сургуульд суралцагсад				